

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

\_\_\_оны \_\_сарын \_\_өдөр

Дугаар\_\_\_

Дархан

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх,  
түр саатуулах хашаа (байр) ажиллуулах,  
төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа (байр) ажиллуулах үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллагаар холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгүүлсүгэй.

2. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа (байр) ажиллуулах, үйл ажиллагааны төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3. Тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах хашаа ажиллуулах, гудамж зам, хамрах хүрээ, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 10/05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ЯНЖМАА

**Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах  
хашаа /байр/-ны төлбөрийн хэмжээ**

Нэг. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /0-10 км-т нэг удаа/	10 км-ээс дээш зайд 1 км тутам /төгрөг/
1.	Мотоцикл	25.000	1926
2.	Суудлын автомашин, микроавтобус /жолоочоос гадна 8-аас илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин	60.000	1926
3.	Бүх жин нь 5000 кг хүртэл ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус, трактор	60.000	4700
4.	Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	90.000	4700

Жич: 1 км тутам тарифыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 тушаал “Зорчигч, ачаа тээврийн жишиг тариф”-т нийцүүлэн тооцсон.

Хоёр. Түр саатуулах хашаа /байр/-ны төлбөрийн хэмжээ

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /нэг хоногт/
1.	Мотоцикл	4.000 төгрөг
2.	Суудлын автомашин, микро автобус /жолоочоос гадна 8-аас илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин	6.000 төгрөг
3.	Бүх жин нь 5000 кг хүртэлх ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус	10.000 төгрөг
4.	Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус	15.000 төгрөг
5.	Тусгай зориулалтын, том оврын тээврийн хэрэгсэл	25.000 төгрөг